



**НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот

Г Нийгмийн даатгалын шимтгэл төлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэр хорооллоос үүдэлтэй агаарын бохирдол хариуцсан мэргэжилтэн Ган-Очирын Даваажаргалын Япон Улсад магистрантурт суралцаж байх хугацаанд төлөгдөөгүй нийгмийн даатгалын шимтгэлийн 676.224 /зургаан зуун далан зургаан мянга хоёр зуун хорин дөрөв/ төгрөгийн өрийг бүрэн төлөхийг мэдэгдсэн тул Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн Төрийн сан дахь дансанд шилжүүлсүгэй.

2. Нийгмийн даатгалын шимтгэлийн 676.224 /зургаан зуун далан зургаан мянга хоёр зуун хорин дөрөв/ төгрөгийн төлбөрийг ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд төлөгдөх шимтгэлийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Цэцэгмаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.ЦАЦРАЛ